



Энэ сонгог тугийн хэвлэл  
дугаар 01 дүгээр сарын 26  
№04 /625/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их  
Хурлын тогтоол

142

**Биеийн тамир, спортыг  
хөгжүүлэх талаар төрөөс  
баримтлах бодлого батлах  
тухай**

Монгол Улсын  
Срэнхийлөгчийн  
зарлиг

149

**Монгол Улсын одон, медалиар  
шагнах тухай**

Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол

159

**Төрийн албан хаагчид болон  
иргэдийг орон сууцаар хангах  
арга хэмжээний тухай**

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

- |     |   |           |     |
|-----|---|-----------|-----|
| 39. | Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай                      | Дугаар 95 | 142 |
| 40. | Хуулийн төсөл буцаах тухай  | Дугаар 96 | 147 |
| 41. | Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай   | Дугаар 97 | 148 |
| 42. | Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг томилж, чөлөөлөх тухай | Дугаар 98 | 148 |

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

- |     |  |            |     |
|-----|--|------------|-----|
| 43. | Монгол Улсын одон, медалиар шагнах тухай | Дугаар 166 | 149 |
|-----|--|------------|-----|

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

- |     |  |            |     |
|-----|--|------------|-----|
| 44. | Жагсаалт батлах тухай  | Дугаар 320 | 156 |
| 45. | Төрийн албан хаагчид болон иргэдийг орон сууцаар хангах арга хэмжээний тухай | Дугаар 321 | 159 |
| 46. | Журам батлах тухай   | Дугаар 326 | 160 |
| 47. | Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай                                    | Дугаар 329 | 166 |
| 48. | Жагсаалт батлах тухай  | Дугаар 335 | 167 |
| 49. | “ЭКСПО 2010. Шанхай” дэлхийн үзэсгэлэнд оролцох тухай                        | Дугаар 337 | 170 |
| 50. | Орон сууц хувьчлах тухай   | Дугаар 338 | 171 |
| 51. | Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай  | Дугаар 344 | 172 |



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 12 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 95

Улаанбаатар  
хот

### Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого"-ыг хавсралтаар баталсугай.

2. "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого"-ын зорилтыг ханган биелүүлэх цогц хөтөлбөр боловсруулж Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт жил бүр тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Д.Арвин/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

Монгол Улсын Их Хурлын 2009 оны  
95 дугаар тогтоолын хавсралт

### БИЕИЙН ТАМИР, СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО

#### Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхийн улс орны хотжилт, техник, технологийн хөгжилтэй холбоотойгоор суурин иргэншил давамгайлах болж, хүн амын амьдралын хэв маяг өөрчлөгдөн улс орнууд биеийн тамир, спортыг дэмжих замаар хүнийг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Монгол Улсын хүн амын 50 гаруй хувь нь хот, суурин газарт амьдарч байгаа бөгөөд хүн амын 70 гаруй хувийг 35 хүртэлх насны хүүхэд, залуучууд эзэлж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр 2005 онд хийсэн шатчилсан судалгаагаар хүүхэд, өсвөр



үеийнхний 80.2 хувь нь бие бялдрын хөгжлийн хувьд "С" буюу түүнээс доош үнэлгээтэй, өөрөөр хэлбэл, тухайн насныхаа бие бялдрын хөгжлийн түвшинд хүрэхгүй, 15-34 насны хүн амын бие бялдрын хөгжлийн үзүүлэлт 35-64 насныхны үзүүлэлтийн дундаж түвшингээс доогуур гарчээ.

Улсын хөгжлийг даган хүн амын амьдралын хэв маяг болон хөдөлмөр эрхлэлт, соёл, иргэншилд гарч байгаа өөрчлөлт нь хүний идэвхтэй хөдөлгөөнийг хязгаарлах, хөдөлгөөний хомсдолтой холбоотой өвчлөл, эндэгдэл нэмэгдэхэд хүргэж байна.

Даяаршлын өнөө үед тив, дэлхийн спортын тавцанд Монголын тамирчдын үзүүлж байгаа амжилт нь тусгаар тогтнолоо бататгах, эх орныхоо хөгжлийн түвшинг илэрхийлэн сурталчлахад онцгой ач холбогдолтой билээ. Түүнчлэн биеийн тамир, спортыг бүх байгууллага, аж ахуйн нэгж дэмжин хөгжүүлэх нь хувь хүний хөгжлийг хангах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй, аюулгүй, нийгэм-эдийн засгийн үр ашигтай аргын нэг юм.

Иймээс хүн амд үзүүлэх биеийн тамир, спортыг Монгол орны нөхцөл байдал, хүн амын хэрэгцээ, онцлогт нийцүүлэн хөгжүүлэх, оюуны болон бие бялдрын өв тэгш хөгжилтэй, хөдөлмөрийн бүтээмж сайтай иргэдтэй байж, биеийн тамирыг хувь хүний хэрэглээ, хамт олон, байгууллагын дүр төрх болгох шаардлагатай байна.

Эдийн засаг, нийгмийн салбарт биеийн тамир, спортын гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, хөгжих нөөц боломжийг эрхэмлэн үзэж, хүний хөгжлийн гол хүчин зүйл болохыг нь онцлон "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого" (цаашид "бодлого" гэх)-ыг тодорхойлов.

Энэхүү бодлогын цөм нь нийтийн биеийн тамир байх бөгөөд биеийн тамир, спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон орон даяар өрнүүлэх, түүний шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, хүн амын ажил, амьдралын салшгүй хэсэг болгох, улмаар Монгол хүний дундаж наслалтыг уртасгах зорилготой юм.

Энэхүү бодлого нь биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлсон үндсэн баримт бичиг юм.

## **Хоёр. Бодлогын зорилго, баримтлах зарчим**

2.1. Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийг хүн амын амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёсны салшгүй хэсэг, амьдралын чанарыг дээшлүүлэх хэрэглүүр болгох, тамирчдын спортын амжилтыг тив, дэлхийн



түвшинд хүргэхэд дэмжлэг үзүүлэхэд бодлогын зорилго оршино.

2.2.Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

2.2.1.биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогын гол чиглэл нь нийтийн биеийн тамир байх;

2.2.2.биеийн тамир, спортын бодлого, арга хэмжээ нь бүх шатны биеийн тамир, спортын байгууллага болон төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжих;

2.2.3.иргэдэд биеийн тамирын хүмүүжил, боловсрол олгох үйл явц шинжлэх ухааны үндэслэлтэй, тасралтгүй, залгамж шинжтэй байх;

2.2.4.биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийг хөгжүүлэхдээ биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын бие даасан, өмчийн олон хэлбэрт тулгуурласан байдлыг хангах;

2.2.5.биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагаа, санхүүжилтийг архи, тамхи болон хууль бус бусад асуудлаас ангид байлгах.

### **Гурав. Бодлогыг хэрэгжүүлэх зорилт**

3.1.Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийг хүн амын амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ажиллах чадварыг дээшлүүлэх хэрэглүүр болгох бодлогын хүрээнд дараахь зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлнэ:

3.1.1.хүүхэд, залуучуудын бие бялдрын хөгжил, соёлыг дээшлүүлэх, тэднийг биеийн тамирын хичээл, секц, дугуйланд тогтмол, тасралтгүй хамрагдан хичээллэх үндсэн нөхцөл болсон заал, танхим, хэрэглэл, материал, техник, тоног төхөөрөмжийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх;

3.1.2.хүн амын бүлэг, нас, ажил, амьдралын онцлог зэрэгт нийцсэн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн хөтөлбөр хэрэгжүүлэхийг дэмжих, иргэдийг амралт, чөлөөт цагаараа ажлын байр болон амьдрах орчиндоо биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтээр хичээллэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх;



3.1.3.биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийг бүх нийтийн хөдөлгөөн болгох, олон улсын стандартын шаардлагад нийцсэн заал, талбай барьж байгуулах, ерөнхий боловсролын сургуулийн заалыг шинэчлэх зэрэг нийтийн ашиг сонирхолд нийцсэн ажил, үйлчилгээ эрхлэх талаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс гарсан санал, санаачилгыг дэмжих.

3.1.4.олон улсын стандартын шаардлагад нийцсэн заал, талбайг улс, бүсийн хэмжээнд спортын тодорхой төрлөөр төрөлжүүлэн барих, ерөнхий боловсролын сургуулийн заал, талбайн стандартыг шинэчлэх, биеийн тамирын заал, талбайгүй сургуулиудыг заал, талбайтай болгох.

3.1.5.хүн ам, ялангуяа хөдөлгөөний хомсдолтой иргэд, ахмад настны дунд биеийн тамир, дасгал, хөдөлгөөнөөр хичээллэх явдлыг дэлгэрүүлэх, чийрэгжүүлэх техник хэрэгсэл, тоногзолын хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх;

3.1.6.хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах.

3.2.Тамирчдын ур чадварыг ахиулах, дасгалжуулалт, сургалт, тэмцээний шаталсан тогтолцоог бүрдүүлж, спортыг хөгжүүлэх, тамирчдыг олимп, тивийн наадам, дэлхийн түвшинд өрсөлдөхүйц чадвартай болгох бодлогын хүрээнд дараахь зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлнэ:

3.2.1.олимп, тивийн наадам, дэлхийн түвшинд хүрсэн спортын төрлүүдийг төрөөс дэмжихийн зэрэгцээ хүүхэд, залуучуудын спортын авьяасыг илрүүлэх, олноор нь хамруулж, хамт олонч хүмүүжил төлөвшүүлж, багийн болон улс орныхоо төлөө зүтгэх эрмэлзлийг төрүүлдэг багийн спортын төрлүүдээр хичээллэх, тэмцээн зохиох, хамрагдан оролцохыг дэмжих.

3.2.2.биеийн тамир, спортыг хөгжүүлэхийн тулд спортын холбоо, клубын тогтолцоог дэмжиж, шилдэг тамирчдын залгамж халаа бэлтгэх шаталсан тогтолцоог боловсронгуй болгох, холбоодын болон үндэсний шигшээ багийн тамирчдын сургалт, дасгалжуулалтад дэмжлэг үзүүлэх;

3.2.3.спортын цол, зэрэг, тамирчид, дасгалжуулагчдын урамшууллыг тэдний хариуцлага, ёс зүйтэй холбох талаар холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох;

3.2.4.олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн



тэмцээнд амжилттай оролцон медаль хүртэж, эх орныхоо нэрийг олон улсын тавцанд гаргасан тамирчин, дасгалжуулагчид олгох урамшууллын хэмжээг нэмэгдүүлэх.

3.2.5.биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн чиглэлээр ажиллаж байгаа ажилтан, арга зүйч, багш, дасгалжуулагчдыг гадаад, дотоодод бэлтгэх, тэдний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх тасралтгүй сургалтын тогтолцоог хөгжүүлж, төрийн болон мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор магадлан итгэмжлэл, тусгай зөвшөөрлийн тогтолцоог нэвтрүүлэх.

3.3.Спортын шинжлэх ухаан, спортын анагаах ухааныг хөгжүүлж, биеийн тамираар хичээллэгсэд болон тамирчдын амжилтыг ахиулах бодлогын хүрээнд дараахь зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлнэ:

3.3.1.спортын анагаах ухааны төвтэй болох, биеийн тамир, спортын эрдэм шинжилгээ, судалгаа, үндэслэл, нотолгоонд тулгуурласан сургалт, дасгалжуулалтыг хөгжүүлэн тамирчдын бэлтгэлийн түвшинг олон улсын жишигт хүргэх;

3.3.2.биеийн тамир, спортын шинжлэх ухааны ажилтан, спортын анагаах ухааны эмч, илээч, сэтгэл зүйч, хоол зүйч, арга зүйчийг бэлтгэх, давтан сургах тогтолцоог сайжруулах;

3.3.3.спорт нь "сэргээшгүй, шударга өрсөлдөөний талбар" гэсэн ойлголтыг нийгэмд төлөвшүүлэх.

3.4.Биеийн тамир, спортын салбарт төрийн ба төрийн бус байгууллагын зохистой түншлэл, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурласан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгох бодлогын хүрээнд дараахь зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлнэ:

3.4.1.биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь спортын холбоод, биеийн тамир, спортын бусад байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж, биеийн тамир, спортын төрийн бодлогыг хэрэгжүүлэх;

3.4.2.гадаад улсын тусламж, олон улсын болон дотоодын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг биеийн тамир, спортын материаллаг баазыг бэхжүүлэхэд чиглүүлж, хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх;

3.4.3.спортод тулгуурласан стратегийн түншлэлийг бий болгон гадаад, дотоодын бизнесийн байгууллага, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх, биеийн тамир, спортыг дэмжигч аж



ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх замаар биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх;

3.4.4. биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагаанд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох, мэдээлэл, удирдлагын тогтолцоог сайжруулах;

3.4.5. нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, стратегийн түншлэлийг бий болгох зорилгоор архи, тамхины онцгой албан татварын тодорхой хувийг Эрүүл мэндийг дэмжих санд хуваарилан, өөрийн эрүүл мэндийн төлөө анхаарал тавьж, биеийн тамир, чийрэгжүүлэлтээр тогтмол хичээллэдэг иргэд, мөн хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх чиглэлээр биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажил, үйлчилгээг эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдийг дэмжих тогтолцоо, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

3.4.6. нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтээр тогтмол хичээллэдэг, мөн хүн амын бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх чиглэлээр биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажил, үйлчилгээг эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдийг тухайн жилд Эрүүл мэндийн даатгалын сангийн эмчилгээ, үйлчилгээнд зарцуулах зардлаас тодорхой хувиар урамшуулах тогтолцоог бүрдүүлэх.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 12 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 96

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Х.Баттулга, С.Ламбаа нарын 2008 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай /шинэчилсэн найруулга/ болон Үндэсний их баяр наадмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 12 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 97

Улаанбаатар  
хот

### Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Зоос банкны бүтцийг өөрчлөн байгуулахтай холбогдон гарч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор 100 хүртэл тэрбум төгрөгийн үнэт цаас гаргаж нийтэд санал болгон арилжаалахыг Засгийн газар /С.Батболд/-т зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 12 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 98

Улаанбаатар  
хот

### Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг томилох, чөлөөлөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн даргаар Галбадрахын Даваажаргал, гишүүнээр Агипарын Бакей, Дамдинсүрэнгийн Цэцэгмаа нарыг тус тус томилсугай.

2. Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсонтой холбогдуулан Лувсандоржийн Дашдорж, Лайлангийн Тунгалаг нарыг Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

3. Энэ тогтоолыг 2009 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2009 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Дугаар 166

Улаанбаатар  
хот

**Монгол Улсын одон, медалиар  
шагнах тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн арван тавдугаар зүйлийн нэгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, хууль эрх зүй, батлан хамгаалах, уул уурхай, эрчим хүч, статистикийн салбарыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулан олон жил үр бүтээлтэй ажилласан доорх хүмүүсийг Монгол Улсын одон, медалиар шагнасугай.

**СҮХБААТАРЫН ОДОН**

1. Гэнэнгийн Элдэв-Очир - МУИС-ын Эдийн засгийн дээд сургуулийн багш
2. Дагвын Мангал - Эрдмийн Ундраа цогцолборын математикийн багш
3. Цээпилийн Нямаа - ЕТГ-ын ахмад ажилтан
4. Вандангийн Алзахгүй - БСШУЯ-ны Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дэд дарга, ажлын албаны захирал
5. Цогныгийн Харнүдэн - Хан-Уул дүүргийн 32-р сургуулийн бага ангийн багш
6. Дүгэрийн Лхагваа - Ахмад холбоочин
7. Тогоочийн Лхагваа - Удирдлагын Академийн багш
8. Дашнямын Гонгор - Нийслэлийн нийгмийн даатгалын газрын дарга
9. Цэвэгсүрэнгийн Нандигжав - Монголын Боксын Холбооны шүүгчдийн зөвлөлийн дарга
10. Дашдаваагийн Жамъяндорж - Чингэлтэй дүүргийн өндөр настай, төр засгийн ахмад ажилтан

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН**

1. Гэээгтийн Оюунбат - Үндэсний статистикийн хорооны ахмад ажилтан



2. Чанцалын Ганзориг - Монгол банкны Эрдэнэсийн сангийн нярав
3. Балдандоржийн Амаржаргал - Ургамал хамгааллын Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал
4. Дүрээгийн Одхүү - УИХ-ын гишүүн
5. Бямбажавын Ганбат - Сангийн яамны газрын дарга
6. Баатарын Эрхэмбаяр - "ГБЭТ" ХХК-ийн захирал
7. Жамбалын Лхагважав - Монголын пара хөнгөн атлетикийн холбооны ахлах дасгалжуулагч
8. Данзангийн Сүрэнхорлоо - Биеийн тамир спортын улсын хорооны спортын хэлтсийн дарга, дэд дарга
9. Бадамын Нямдорж - Улсын Филармоны Ерөнхий удирдаач
10. Очирын Цэрэндулам - Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтсийн дарга
11. Үзэгийн Сагараажав - Эх үрсийн холбоо эмнэлгийн захирал
12. Гатавын Чулуунхүү - Увс аймгийн Баруунтуруун сумын Усны аж ахуйн газрын механикч
13. Цэдэвийн Оюун-Орших - Увс аймгийн Баруун туруун сумын ОБЕГ-ын харъяа улсын үрийн нөөцийн ажилтан
14. Лосолын Бямбажаргал - Дээд судалгааны хүрээлэнгийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга
15. Сонгины Энхбаатар - Нийслэлийн татварын газрын дарга
16. Тогтохын Чойжилсүрэн - Хүүхэд залуучуудын театрын ахмад ажилтан
17. Нянданямын Алтанхуяг - ХАА-н хүрээлэнгийн мэргэжилтэн

#### АЛТАН ГАДАС ОДОН

1. Доржийн Хорлоо - Харааны бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулийн багш
2. Сүрэнжавын Тэгшжаргал - Үндэсний статистикийн хорооны ахмад ажилтан
3. Ишийн Маахүү - Хэнтий аймгийн Статистикийн хэлтэс
4. Хайнзангийн Оюунцэцэг - Үндэсний статистикийн хорооны ахмад ажилтан



5. Баваасангийн Цэвээн - Үндэсний статистикийн хорооны ахмад ажилтан
6. Цэрэннадмидын Дүгэрсүрэн - Үндэсний статистикийн хорооны ахмад ажилтан
7. Готовын Бадамханд - Үндэсний статистикийн хорооны ахмад ажилтан
8. Шаравын Доржханд - Үндэсний статистикийн хорооны тамгын газрын мэдээллээр үйлчлэх төвийн ажилтан
9. Баясгалангийн Дуламсүрэн - Үндэсний статистикийн хорооны ахмад ажилтан
10. Дашбалжирын Бат-Өлзий - "Сандэй" ХХК-ийн ерөнхий захирал
11. Дэндэвийн Хашхүү - ХУД-ийн өндөр настан
12. Шаравын Доржлагам - СБД-ийн өндөр настан
13. Гэлэнхүүгийн Оюун - Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн их эмч
14. Өлзийхутагийн Мангалсүрэн - Сүхбаатар аймгийн Асгат сумын өндөр настан
15. Пүрэвийн Сүхбаатар - Монгол банкны Хяналт шалгалтын газрын шалгагч
16. Малиагийн Виктор - Нэгдсэн 2-р эмнэлгийн эмч
17. Ярамгайн Сүрэнжав - "Үнэт үг" ХХК-ийн захирал
18. Батын Гүнцээ - УБТЗ-ын замын 2-р ангийн өндөр настан
19. Авирмэдийн Наранцэцэг - УМХЕГ-ын мэргэжилтэн
20. Пүрэвийн Баяр - "Моннис Интернэшл" ХХК-ийн Ерөнхий менежер
21. Халзангийн Баярсайхан - Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн ажилтан
22. Дуламын Батжаргал - Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн ажилтан
23. Ерөөлтийн Сагсай - Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор
24. Гэндэнгийн Бадамханд - Чингэлтэй дүүргийн прокурор
25. Сэрээжамъянгийн Даваасамбуу - Дархан-Уул аймгийн иргэн



26. Равжирын Цэнд-Аюуш - Увс аймгийн Наранбулаг сумын "Тулгат" хувийн мал эмнэлгийн малын эмч
27. Чогдонгийн Дүрээ - Тээврийн эрдэм шинжилгээний институтийн ахмад настан
28. Цэрэнгийн Юнгээ - Налайх дүүргийн өндөр настан
29. Гомбосүрэнгийн Энхээ - Дорнод аймгийн Хэрлэн сумын 4-р багийн Засаг дарга
30. Дэндэвийн Дарамбазар - Дорнод аймгийн Хэрлэн сумын өндөр настан
31. Бийцээгийн Үнэнбат - УМХЕГ-ын Тамгын газрын дарга
32. Ядамжавын Нямаа - Гаалийн Ерөнхий Газрын хэвлэлийн цехийн дарга
33. Цэдэвийн Дангаасүрэн - СБ дүүргийн хангамж үйлчилгээний дарга
34. Тайсаагийн Даваажав - ХААДС-ийн багш
35. Пүрэвийн Алтангэрэл - УИХ-ын гишүүн
36. Гомбожавын Хаянхярваа - "Очир төв" ХХК-ийн автогрейдерчин
37. Ваанчигийн Сумъяасүх - Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн спорт цогцолборын орлогч захирал
38. Лувсандоржийн Эрдэнэсүвд - "Анхны оч" өрхийн эмнэлгийн ахлагч, эмч
39. Доржийн Оюун-Эрдэнэ - "Хос чагнуур" өрхийн эмнэлгийн ахлагч, эмч
40. Дашнямын Санжмятав - "Бадрах эмнэлэг"-ийн захирал, чих хамар хоолойн эмч
41. Баттөрийн Мягмаржав - МҮОНР-ийн сурвалжлагч, редактор
42. Билэгтийн Бямбасүрэн - Налайхын ДЦС-ын нягтлан
43. Нямын Отгон - Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн их эмч
44. Доржготовын Лянхуа - Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн багийн ахлагч эмч
45. Цэрэндуламын Цэвээнханд - Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн тасгийн эрхлэгч

46. Дашдоржийн Энхтуяа - Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн их эмч

47. Гомбын Дашдондог - Төв аймгийн Баянчандмань сумын Монгол - Солонгосын коллежийн багш

48. Гомбын Дулмаа - Анагаах ухааны "Оточ" дээд сургуулийн багш, хүний их эмч

49. Сумъяагийн Чагцаа - Ерөнхий Боловсролын 13-р сургуулийн багш

50. Дэрдэгээгийн Болд - Ерөнхий Боловсролын 79-р сургуулийн захирал

51. Лувсангийн Дэнсмаа - Барилга архитектур корпорацийн эрдэм шинжилгээний ажилтан

52. Чимэг-Очирын Халтар - Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын хүн эмнэлгийн их эмч

53. Аюурзаны Энхжаргал - Эхлэл дунд сургуулийн захирал

54. Цэрэндэмбэрэлийн Магвандорж - 25-р тусгай сургуулийн хичээлийн эрхлэгч асан

### **ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОН**

1. Дэндэвноровын Эрдэнэсайхан - Нийслэлийн цагдаагийн газрын ёс журмын ахлах офицер, дэд хурандаа

2. Намсрайн Гэлгээ - БЗД-ийн өндөр настан

3. Ичинноровын Одхүү - БХЯ-ны ерөнхий нягтлан, хурандаа

### **ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ**

1. Хасбазарын Чимэддорж - Үндэсний статистикийн хорооны макро эдийн засаг, статистикийн газрын шинжээч

2. Авирмэдийн Амарбал - Үндэсний статистикийн хорооны хүн ам, орон сууцны тооллогын товчооны дарга

3. Балдандоржийн Пүрэвжал - Баянгол дүүргийн статистикийн хэлтсийн мэргэжилтэн

4. Жамъянбалдангийн Буд - Налайх дүүргийн статистикийн хэлтсийн дарга

5. Чүлтэмийн Лхамдийдэрмаа - Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн



6. Баясгалангийн Буяндэлгэр - Үндэсний статистикийн хорооны хүн ам нийгмийн статистикийн газрын хүн ам орон сууцны тооллогын товчооны шинжээч

7. Маналжавын Оюун - Үндэсний статистикийн хорооны хяналт үнэлгээ мониторингийн газрын шинжээч

8. Дугарбаатарын Нямсүрэн - Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын шинжээч

9. Сагдагийн Ханд - Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын нягтлан бодогч

10. Магсарсүрэнгийн Баасанжав - Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын шинжээч

11. Шаравсэнгийн Оюунгэрэл - Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын ахлах шинжээч

12. Цэвэгжавын Нарантуяа - Сүхбаатар дүүргийн Статистикийн хэлтсийн дарга

13. Банзрагчийн Алтангэрэл - Сонгино хайрхан дүүргийн Статистикийн хэлтсийн дарга

14. Бэгзээгийн Энхцэцэг - Баянгол дүүргийн Статистикийн хэлтсийн дарга

15. Дашнямын Энхжаргал - Хан-Уул дүүргийн Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

16. Намралын Батбүүрэг - Ховд аймгийн Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

17. Гарамхандын Баясгалан - Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

18. Бэгзжавын Эрдэнэбаяр - Орхон аймгийн Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

19. Хантарбайн Рыс - Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

20. Цэндсүрэнгийн Хад - Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

21. Хоогийн Оюунчимэг - Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

22. Рэнцэндагвын Сарантуяа - Увс аймгийн Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн



23. Цэвэлсүрэнгийн Доржлалам - Үндэсний статистикийн хорооны ахмад ажилтан
24. Бадамжунай Цэрэнсоль - Үндэсний статистикийн хорооны ахмад ажилтан
25. Банзайн Надмид - Үндэсний статистикийн хорооны ахмад ажилтан
26. Зундуйн Даваасүрэн - Үндэсний статистикийн хорооны ахмад ажилтан
27. Баатарын Давааням - Увс аймгийн Зүүнтурууны Сангийн аж ахуйн захирал
28. Бямбасүрэнгийн Бат-Ирээдүй - "МТС" ХХК-ийн нягтлан
29. Төмөрбаатарын Оюунсүвд - Нийслэлийн өмчийн харилцааны газрын мэргэжилтэн
30. Хэцүүсүрэнгийн Сэлэнгэ - Нийслэлийн өмчийн харилцааны газрын мэргэжилтэн
31. Цэрэнжамцын Ганболд - "Монтед" ХХК-ийн захирал
32. Зундуйн Артаг - "Очир төв" ХХК-ний автогрейдчин
33. Очирын Ганчулуун - Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн их эмч
34. Догсомын Хандсүрэн - Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн материал техник хангамжийн баазын ахмад ажилтан
35. Ёндонрашийн Машбат - Уулын Баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн авто тээврийн байгууллагын ахмад ажилтан
36. Мангын Төгсжаргал - "Эрдэнэт" фермерийн захирал
37. Жадамбын Дамба - Орхон аймгийн өндөр настан
38. Нанзадын Оюунцэцэг - Улаанбаатар өртөөний ачаа вагон хүлээлцэгч
39. Нортовын Амар - Монгол банкны судалгаа шинжилгээний хэлтсийн дарга
40. Хашхүүгийн Дэлгэр - Монгол банкны валют, эдийн засгийн газрын ахлах эдийн засагч
41. Бадрахын Батбаяр - Дарханы Төмөрлөгийн үйлдвэрийн ажилтан
42. Баянбаатарын Отгонбаатар - Дарханы Төмөрлөгийн үйлдвэрийн





ажилтан

43. Сүхбаатарын Энхтуяа - Дарханы Төмөрлегийн үйлдвэрийн ажилтан

44. Шарын Нарантуяа - Монгол улсын Шадар сайдын зөвлөх

### ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ

1. Бадамдоржийн Ганболд - Төрийн тусгай хамгаалалтын газрын 2-р тусгай тасгийн дарга, хошууч

2. Идишийн Мөнх-Амар - Төрийн тусгай хамгаалалтын газрын 3-р тусгай тасгийн дарга, ахмад

3. Долгорсүрэнгийн Тэмүүлэн - Төрийн тусгай хамгаалалтын газрын гадуур хамгаалалтын албаны ахлах ажилтан, хошууч

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 10 дугаар  
сарын 14-ний өдөр

Дугаар 320

Улаанбаатар  
хот

#### Жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.12-т заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Засгийн газраас эхний ээлжинд хэрэгжүүлэх томоохон төслийн жагсаалт"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Засгийн газраас эхний ээлжинд хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлийн томоохон төслийн жагсаалтыг нийтэд зарлах, сурталчлах, төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, техникийн нөхцөл олгох ажлыг зохион байгуулахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашчулуун), Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт даалгасугай.

3. Жагсаалтад тусгагдсан төслүүдийг хэрэгжүүлэхэд төлөвлөлт.



салбар хоорондын уялдааг хангаж, хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэн, хэрэгжилттэй холбоотой зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгор, Сангийн сайд С.Баярцогт, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашнулуун)-нд үүрэг болгосугай.

4. Дээрх төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчны үнэлгээ хийхэд мэргэжил арга зүйн туслалцаа, бодлогын дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН  
ШАДАР САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Б.ДОЛГОР**

Засгийн газрын 2009 оны 320 дугаар  
тогтоолын хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРААС ЭХНИЙ ЭЭЛЖИНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ТОМООХОН ТӨСЛҮҮДИЙН ЖАГСААЛТ**

№	Төслийн нэр	Төслийн баримжаалсан төсөвт өртөг (сая.ам.дол)	Төсөл хэрэгжүүлэх хугацаа
Тэргүүлэх чиглэл 1. Ашигт малтмалын ордуудыг ашиглан уул уурхайн салбарыг хөгжүүлж, хүнд аж үйлдвэрийн суурийг тавих			
1	"Оюутолгой" төсөл	4000.0	2010-2015
2	"Тавантолгой" төсөл	800.0	2010-2015
3	"Зэс хайлах үйлдвэр" төсөл	1000.0	2010-2015
4	"Хар металлургийн цогцолбор" төсөл	1000.0	2011-2016
5	"Кокс химийн үйлдвэр" төсөл	700.0	2010-2015



6	"Газрын тос боловсруулах үйлдвэр" төсөл	900.0	2011-2015
7	"Нүүрс химийн үйлдвэр" төсөл	1000.0	2010-2015
8	"Барилгын материалын үйлдвэр" төсөл	800.0	2010-2015
Тэргүүлэх чиглэл 2. Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлэх, аж үйлдвэржүүлэх бодлогыг хэрэгжүүлэх			
9	Малыг эрүүлжүүлж мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх "Эрүүл хүнс" төсөл	150.0	2010-2015
10	"Усалгаатай тариалангийн хөгжлийг дэмжих" төсөл	50.0	2010-2015
11	"Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж" төсөл	50.0	2010-2011
12	"Өндөр технологийн аж үйлдвэрийн цогцолбор, шинжлэх ухаан- үйлдвэрлэлийн парк" төсөл	400.0	2010-2015
Тэргүүлэх чиглэл 3. Дад бүтцийг хөгжүүлэх			
13	"Тавантолгойн цахилгаан станц" төсөл	400.0	2010-2015
14	"Шинэ төмөр зам" төсөл	800.0	2010-2015
15	"Орхон голоос говийн бүс нутгийн усны хэрэгцээг хангах" төсөл	540.0	2010-2015
16	"Монгол Улсын сансрын холбооны үндэсний хиймэл дагуул" төсөл	600.0	2010-2015
17	"Улаанбаатар хотын авто замын шинэчлэл" төсөл	900.0	2010-2015
18	"Олон улс, улсын болон орон нутгийн чанартай авто зам барих" төсөл	1200.0	2010-2015
19	"Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны зам" төсөл	1200.0	2010-2015



20	"Эрчим хүчний тавдугаар станц" төсөл	300.0	2011-2016
21	"Хүн амыг орон сууцаар хангах" төсөл	2100.0	2010-2015
22	"Хог хаягдал, биомассаас эрчим хүч үйлдвэрлэх" төсөл	200.0	2010-2015

Тэргүүлэх чиглэл 4. Хүний хөгжлийг төлөвшүүлж, байгаль орчныг хамгаалан тогтвортой хөгжлийг хангах

23	"Мэдээллийн технологийн сургалт үйлдвэрлэлийн хотхон" төсөл	100.0	2010-2015
24	"Оюутны хотхон" төсөл	300.0	2010-2015
25	Аялал жуулчлалын "Хар хорум ХШ зуун" төсөл	500.0	2010-2015
26	Ахуйн болон үйлдвэрийн бохир усыг цэвэрлэх "Эко" төсөл	200.0	2010-2015

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 10 дугаар  
сарын 14-ний өдөр

Дугаар 321

Улаанбаатар  
хот

**Төрийн албан хаагчид болон  
иргэдийг орон сууцаар хангах  
арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Барилгын салбарт үүсээд байгаа санхүүгийн хүндрэлийг шийдвэрлэх, арилжааны банкуудын хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодын зах зээл дээр 180.0 (нэг зуун наян) тэрбум хүртэлх төгрөгийн Засгийн газрын бондыг үе шаттайгаар арилжаалах замаар төрийн албан хаагчид болон иргэдэд олгох орон сууцны урт хугацаат зээлийн эх үүсвэр бүрдүүлэхийг Сангийн сайд С.Баярцогтод даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдоржид зөвлөсүгэй.

2. Барьж дууссан улсын комисст хүлээлгэн өгсөн арилжааны банкны зээлийн барьцаанд байгаа орон сууцныг м2 талбайн үнийг 650.0 (зургаан зуун тавин) мянган төгрөгөөс хямд байх (нийслэлд) зарчим баримтлан "Орон сууцны санхүүжилтийн корпораци" ХХК-иар дамжуулан төрийн албан хаагчдад урт хугацаатай зээлээр олгохыг Сангийн сайд



С.Баярцогт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр нарт даалгасугай.

3. Засгийн газрын бондын арилжаалан төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэгдлийг арилжааны банкуудаар дамжуулан зөвхөн орон сууцны урт хугацаат зээлийн зориулалтаар иргэдэд олгох үйл ажиллагааг зохион байгуулахыг Сангийн сайд С.Баярцогт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт тус тус даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдоржид зөвлөсүгэй.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг улирал тутам Засгийн газарт танилцуулж байхыг Сангийн сайд С.Баярцогт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН  
ШАДАР САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

**Х.БАТТУЛГА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 10 дугаар  
сарын 21-ний өдөр

Дугаар 326

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах журам"-ыг 1 дүгээр, "Медаль хүртсэн тамирчныг шагнах мөнгөн шагналын хэмжээ"-г 2 дугаар, "Үндэсний хэмжээний тэмцээний мөнгөн шагналын хэмжээ, түүнийг олгох журам"-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2008 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 241 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН  
ШАДАР САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД**

**С.ЛАМБАА**

**ОЛИМП, ТИВИЙН НААДАМ, ДЭЛХИЙН ЗЭРЭГЛЭЛИЙН  
ТЭМЦЭЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦОЖ МЕДАЛЬ ХҮРТСЭН  
ТАМИРЧИН, ТҮҮНИЙ ДАСГАЛЖУУЛАГЧИЙГ ШАГНАЖ  
УРАМШУУЛАХ ЖУРАМ**

1. Олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд сонирхогчдын спортын төрлөөр оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг Засгийн газраас мөнгөн шагналаар шагнаж урамшуулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

2. Тэмцээний ангилал, зэрэглэл, тухайн жин, зай, төрөлд оролцсон орны тооноос хамааран тамирчин, дасгалжуулагчид дор дурдсан хувь хэмжээний мөнгөн шагналыг олгоно:

№	Тэмцээний		Жин, зай, төрөл тус бүрт оролцсон орны тоо		Олгох мөнгөн шагналын (хувь хэмжээ)
	Ангилал	Зэрэглэл	Эрэгтэй	Эмэгтэй	
1	Олимпын наадам	Олимп	Оролцогч орны тоо харгалзахгүй		100
		Паралимп			
		Дифлимп	24 болон түүнээс дээш	20 болон түүнээс дээш	100
			17-23	14-19	60
			10-16	8-13	30
	9 хүртэлх	7 хүртэлх	10		
2	Дэлхийн	Дэлхийн аварга, Дэлхийн цом, Дэлхийн тоглолт Универсиад	32 болон түүнээс дээш	24 болон түүнээс дээш	100
			21-31	17-23	60
			16-20	12-16	30
			15 хүртэлх	11 хүртэлх	10



3	Тивийн	Тивийн наадам	16 болон түүнээс дээш	12 болон түүнээс дээш	100
			12-15	9-11	60
			9-11	6-8	30
			8 хүртэлх	5 хүртэлх	10

3. Тамирчин дэлхийн цомын төлөөх шигшээ тэмцээнд тив, бүс нутаг төлөөлөн болон нэр заагдан оролцвол оролцогч орны тоог харгалзахгүйгээр шагналын 30 хувийг олгоно.

4. Өсвөр үеийнхний Олимпын наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчинд оролцсон орны тоог харгалзахгүйгээр Олимпын наадмын шагналын 30 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналыг олгоно.

5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчинд энэхүү журмын 2, 3, 4 дэх заалтад заасан тэмцээний ангилалд ногдох мөнгөн шагналыг олгоно.

6. Дэлхийн цомын төлөөх цувралаар явагддаг тэмцээнд тамирчны үзүүлсэн хамгийн өндөр амжилтад тохирох мөнгөн шагналыг тухайн жилд нэг удаа олгоно.

7. Багийн спортын төрлөөр медаль хүртсэн багийн тамирчин тус бүрт оролцсон орны тоог харгалзахгүйгээр медальд ногдох мөнгөн шагналын 30 хувьтай тэнцэх шагналыг олгоно.

8. Тамирчны хувийн болон багийн нэг удаагийн амжилтаар тооцон медаль олгодог спортын төрөлд мөнгөн шагналыг давхардуулахгүйгээр тухайн тамирчны үзүүлсэн хамгийн өндөр амжилтаар тооцон олгоно.

9. Тухайн тэмцээнд тамирчныг бэлтгэж оролцуулсан дасгалжуулагчид тамирчинд олгогдох шагналын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал тусад нь олгоно.

10. Мөнгөн шагнал авах болзол хангасан тамирчинтай 1-ээс дээш дасгалжуулагч ажилласан тохиолдолд дасгалжуулагчдад олгох мөнгөн шагналыг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас спортын төрөл тус бүрийн онцлогийг харгалзан баталсан журмын дагуу олгоно.



11. Шатрын, зуун буудалт даамын төрлөөр олон улсын их мастер (Гроссмейстер)-ын цол хүртсэн тамирчинд тивийн наадмын алтан медальд ногдох мөнгөн шагнал олгоно.

12. Мөнгөн шагнал авах болзол хангасан тамирчин, дасгалжуулагчийн хамаарах спортын холбоо нь биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад дараахь материалыг тэмцээн дууссанаас хойш 21 хоногийн дотор ирүүлнэ:

12.1. тухайн тэмцээний албан ёсны урилга, уг тэмцээний заавар, оролцох журам;

12.2. тэмцээнд оролцох бүрэлдэхүүнийг баталсан биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хуулбар;

12.3. тэмцээнд медаль авсныг нотолсон баримт, диплом, гэрчилгээ, хуулбарын хамт;

12.4. тухайн тэмцээний протоколыг байрлуулсан интернэтийн вэб сайтын танилцуулга;

12.5. тамирчныг мөнгөн шагналаар шагнуулах хүсэлт;

12.6. залуучууд, өсвөр үеийнхний тэмцээнд оролцсон тамирчдын төрсний гэрчилгээ болон иргэний үнэмлэхийн хуулбар.

13. Универсиад, залуучууд, өсвөр үеийн тэмцээнд нас дарж орсон тохиолдолд мөнгөн шагналыг олгохгүй.

14. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэхүү журмын 12 дахь заалтад заасан материалыг хянаж, мөнгөн шагнал олгуулах тухай саналаа биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

15. Мөнгөн шагнал олгуулах асуудлыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

16. Тамирчин, түүний дасгалжуулагчид мөнгөн шагнал олгох Засгийн газрын шийдвэрийг үндэслэн биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мөнгөн шагналыг олгож, бүрдүүлсэн материалыг хадгална.



**МЕДАЛЬ ХҮРТСЭН ТАМИРЧНЫГ ШАГНАХ МӨНГӨН  
ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ**

(сая.төг)

№	Тэмцээний		Мөнгөн шагналын хэмжээ (тамирчдын насны ангилал, медалиар)											
			Насанд хүрэгчид				Залуучууд				Өсвөр үе			
	Зэрэглэл	Ангилал	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл
1	Олимпын наадам	Олимп	120.0	60.0	30.0	-	-	-	-	-	-	-	-	-
		Паралимп												
		Дифлимп												
2	Дэлхийн	Дэлхийн аварга	30.0	15.0	8.0	12.0	6.0	3.0	5.0	3.0	2.0	-	-	
		Дэлхийн цом	20.0	10.0	5.0	-	-	-	-	-	-	-	-	
		Дэлхийн тоглолт	20.0	10.0	5.0	-	-	-	-	-	-	-	-	
		Универсиад	10.0	5.0	3.0	-	-	-	-	-	-	-	-	
3	Тивийн	Тивийн наадам	14.0	7.0	4.0	-	-	-	5.0	3.0	2.0	-		



**ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ТЭМЦЭЭНИЙ МӨНГӨН  
ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ**

1. Үндэсний хэмжээнд зохион байгуулж байгаа монголын бүх ард түмний, хүүхдийн, оюутны, үндэсний спортын их наадам, улсын аварга шалгаруулах тэмцээн (цаашид "тэмцээн" гэх)-д амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг мөнгөн шагналаар шагнаж урамшуулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

2. Медаль хүртсэн тамирчинд дор дурдсан хэмжээний мөнгөн шагнал олгоно:

№	Тэмцээний		Медалийн төрөл	Мөнгөн шагналын хэмжээ (мян. төг)
	Ангилал	Зэрэглэл		
1	Спортын их наадам	Монголын бүх ард түмний	Алт	1500.0
			Мөнгө	1000.0
			Хүрэл	500.0
		Оюутны, үндэсний, хүүхдийн	Алт	600.0
			Мөнгө	400.0
			Хүрэл	200.0
2	Улсын аварга	Насанд хүрэгчид	Алт	600.0
			Мөнгө	400.0
			Хүрэл	200.0
		Залуучууд, өсвөр үе	Алт	400.0
			Мөнгө	200.0
			Хүрэл	100.0

3. Тэмцээнд дасгалжуулсан багаа медальт байранд шалгаруулсан багийн дасгалжуулагчид энэхүү журмын 2 дахь заалтад заасан тэмцээний ангилалд ногдох мөнгөн шагналыг олгоно.

4. Багийн спортын төрлөөр медаль хүртсэн багийн тамирчин тус бүрт тухайн медальд ногдох мөнгөн шагналын 30 хувьтай тэнцүү хэмжээний мөнгөн шагнал олгоно.

5. Хөнгөн атлетик, тэшүүр, буудлага зэрэг хэмжигдэхүүнээр



амжилтыг нь тооцдог спортын төрлөөр Монгол Улсын рекорд амжилтыг шинэчлэн тогтоосон тохиолдолд тамирчинд олгох мөнгөн шагналыг 30 хувиар нэмэгдүүлэн олгоно.

6. Тэмцээн зохион байгуулсан спортын холбоо нь биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тэмцээний тайлан, протоколыг тэмцээн дууссанаас хойш 14 хоногийн дотор ирүүлнэ.

7. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь спортын холбоодоос ирүүлсэн тэмцээний протокол, тайланг хянаж мөнгөн шагнал олгох тухай шийдвэр гаргана.

8. Дараахь тохиолдолд мөнгөн шагнал олгохгүй:

8.1. тэмцээний протокол, тайлан, тамирчинд олгох шагналтай холбогдсон материалыг бүрэн бүрдүүлээгүй, хугацаандаа ирүүлээгүй;

8.2. өсвөр үе, залуучуудын тэмцээнд нас дарж орсон.

9. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тамирчин, дасгалжуулагчид мөнгөн шагналыг олгож, бүрдүүлсэн материалыг хадгална.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 10 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 329

Улаанбаатар  
хот

### Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүний тухай" Засгийн газрын 2008 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 6 дугаар тогтоолын хавсралтад дор дурдсан агуулга бүхий 31 дэх заалт нэмсүгэй:

"31. Монгол Улс, Европын чөлөөт худалдааны холбооны гишүүн орнууд хоорондын хамтарсан хорооны Монголын хэсэг

Дарга –Гадаад харилцааны сайд."

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2009 оны 11 дүгээр  
сарын 04-ний өдөр

Дугаар 335

Улаанбаатар  
хот**Жагсаалт батлах тухай**

2009 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь.

1. Гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх томуугийн А хүрээний (H1N1) вирусийн халдварын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зориулалт бүхий оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгалын бодисын жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодисын үнийг зохиомлоор өсгөх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор тэдгээрийг нийлүүлэх аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан эмийн санд зарагдаж байгаа үнийн хэмжээнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад даалгасугай.

3. Томуугийн А хүрээний (H1N1) вирусийн халдвар тархаж байгаа үед витамин, дархлаа сайжруулах болон томуугийн эсрэг эм, амны хаалт, хүнсний зарим бүтээгдэхүүний үнэ өсч байгаад холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавих арга хэмжээ авахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуягт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД****С.БАТБОЛД****ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД****С.ЛАМБАА**Засгийн газрын 2009 оны 335 дугаар  
тогтоолын хавсралт

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАР БОЛОН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН  
ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ОНОШЛУУР, ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ,  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, АРИУТГАЛЫН БОДИСЫН ЖАГСААЛТ**

Нэг, Эм

№	БТКУС-ийн код	Эмийн нэр
1	3004.90	Тамифлю /Оселтамивир фосфат/ / TAMIFLU (oseltamivir phosphate)/
2	3004.90	Арбидол



3	3004.90	Занамивир
4	3004.90	Ингавирин
5	3002.20	H1N1 вирусээр үүсгэгдсэн томуугийн эсрэг шаардлага хангасан вакцин*

\* Үйлдвэрлэгчийн нэрийг нь Эрүүл мэндийн сайдын тушаалаар заасан вакцин

Хоёр. Эмнэлгийн хэрэгсэл

№	БТКУС-ийн код	Эмнэлгийн хэрэгслийн нэр
1	6307.90.00	N95 амны хаалт
2	6505.90.90	Нэг удаагийн малгай
3	6210.10.00	Нэг удаагийн нөмрөг
4	3926.20.00	Нэг удаагийн улавч
5	6307.90.00	Нэг удаагийн амны хаалт
6	6210.10.00	Нэг удаагийн хамгаалалтын хувцасны иж бүрдэл
7	9025.19.00	Дижитал халуун хэмжигч
8	9025.19.00	Зайнаас халуун хэмжигч
9	9018.90.00	Трахеостомын мэс заслын багажны иж бүрдэл
10	9018.90.00	Трахеостомын гуурс
11	9018.90.00	Интубацийн гуурс
12	6307.90.00	Шүүлтүүртэй маск
13	7311.00.00	Хүчилтөрөгчийн баллон



## Гурав. Оношлуур

№	БТКУС-ийн код	Оношлуурын нэр
1*	3822.00.00	Сорьцоос РНХ ялгах урвалж Үйлдвэрлэгч компанийн нэр: -"Viral RNA kit QIAGEN" -"Bioneer"
2*	3822.00.00	Полимеразын гинжин урвалын оношлуур Үйлдвэрлэгч компанийн нэр: -"QIAGEN", -"Bioneer"
3*	3822.00.00	Полимеразын гинжин урвалын оношлуур Оношлуурын оноосон нэр: -"SuperScript TM Ш One-Step RT-PCR with Platinum® Tag" Үйлдвэрлэгч компанийн нэр: -"Invitrogen"
4	3923.90.00	Вирус тээвэрлэх орчин, дакрон бамбарын хамт (HealthLink UTM medium for the transport of viruses, with swab)
5	70.17	Пипеткийн хошуу (Филтэртэй, ариун) 0.2-10 мкл; 2-20 мкл; 20-200 мкл; 200-800 мкл

\* Зөвхөн нэр заасан үйлдвэрлэгчийн урвалж оношлуур  
хамаарна.

## Дөрөв. Тоног төхөөрөмж

№	БТКУС-ийн код	Тоног төхөөрөмжийн нэр
1	9019.20.00	Амьсгалын аппарат
2	9018.19.00	Өвчтөнийг хянах монитор
3	9019.20.00	Хүчилтөрөгч-эмчилгээний хэрэгсэл



4	9018.90.00	Дуслын автомат шахуурга
5	9019.20.00	Хүүхдийн амбу
6	9019.20.00	Том хүний амбу
7	9019.20.00	Утлагын аппарат
8	8421.39.00	Агаар цэвэршүүлэгч /ионизатор/
9	9018.19.00	Нярайн болон том хүний пульсоксиметр
10	8424.20.00	Автомат /Ариутгалын бодис шүршигч/
	8424.89.00	
11	9018.39.00	Соруулах төхөөрөмж /Suction unit/
12	9018.90.00	Ларингоскоп

## Тав. Ариутгалын бодис

№	БТКУС-ийн код	Ариутгалын бодисын нэр
1	3004.90.90	Хлорамин
2	3004.90.90	Жавель
3	3004.90.90	Клорсепт
4	3808.94.00	Гар халдваргүйжүүлэх спиртэн уусмал

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 11 дүгээр  
сарын 04-ний өдөр

Дугаар 337

Улаанбаатар

### "ЭКСПО 2010. Шанхай" дэлхийн үзэсгэлэнд оролцох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. БНХАУ-ын Шанхай хотноо 2010 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс  
10 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулагдах



"ЭКСПО 2010" дэлхийн үзэсгэлэнд Монгол Улсыг оролцуулах Ерөнхий зохицуулагчаар Гадаад харилцааны яамыг, Ерөнхий комиссараар Гадаад харилцааны сайдыг, Ерөнхий зохион байгуулагчаар Гадаадын хөрөнгө оруулалтын газар, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамыг тус тус ажиллуулсугай.

2. "ЭКСПО 2010. Шанхай" дэлхийн үзэсгэлэнд Монгол Улсыг оролцуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллах, үзэсгэлэнд оролцсон дүнг Засгийн газарт танилцуулахыг Гадаад харилцааны сайд, монголын талын Ерөнхий комиссарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Үзэсгэлэнд оролцох тухай" Засгийн газрын 2007 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 118 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

**Ц.НЯМДОРЖ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2009 оны 11 дүгээр  
сарын 04-ний өдөр

Дугаар 338

Улаанбаатар  
хот

### **Орон сууц хувьчлах тухай**

Орон сууц хувьчлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 1, Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн Ерөнхий хорооны хурлын 2009 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн протоколыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн эзэмшлийн 899 орон сууцыг үнэ төлбөргүйгээр сууц эзэмшигчдэд нь хувьчлах ажлыг 2009, 2010 онуудад зохион байгуулахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

**Х.БАТТУЛГА**



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2009 оны 11 дүгээр  
сарын 18-ны өдөр

Дугаар 344

Улаанбаатар

**Журамд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай**

Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 11 дэх хэсгийг үндэслэн  
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2007 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 280 дугаар тогтоолоор баталсан "Хүүхдэд зориулсан уран бүтээл туурвихад төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-д дор дурдсан агуулга бүхий "4.3.5", "4.3.6", "4.6" дахь заалт нэмсүгэй:

а/4.3.5. төслийн багийн танилцуулга, ажлын туршлага,"

б/4.3.6. албан бичиг, хүсэлт өргөдөл."

в/4.6. Төслийн шалгаруулалтыг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана."

2. Мөн журмын 4.1 дэх заалтыг "Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд уран бүтээлийн ямар төрөл, сэдвээр шалгаруулалт явуулахыг тодорхойлно." гэж, мөн журмын 4.2 дахь заалтыг "Шалгаруулалтыг жилд нэг удаа зохион байгуулна." гэж тус тус өөрчлөн найруулсугай.


**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД****С.БАТБОЛД****БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД****Ё.ОТГОНБАЯР****Хаяг:**

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци  
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turin\_medeelel@parliament.mn

**Утас:** 262420, 329612

Хэвлэлийн хуудас 2

**Индекс: 14003**



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэл хэргийн хэлтэс хэвлэв.  
Утас 329487